

ХИППО ОЛОН УЛСЫН АНГЛИ ХЭЛНИЙ ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

ХИППО ОЛОН УЛСЫН АНГЛИ ХЭЛНИЙ ОЛИМПИАД нь 13 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд сургуулийн болон ганцаарчилсан бүртгэл авч байна. Сургуулиуд бүс, байршил хамаарахгүйгээр Монголын өнцөг булан бүрд суралцаж буй 6-19 насны сурагчид өөрийн харгалзах түвшинд оролцох боломжтой.

ХИППО ОЛИМПИАДЫН ЗОРИЛГО

Олон улсын Хиппо Англи хэлний олимпиадын зорилго нь Англи хэлийг сурталчлах, дэлхийн өнцөг булан бүрд байгаа ижил сонирхол бүхий сурагчдын дунд найрсаг харилцаа, эрүүл, нөхөрсөг өрсөлдөөнийг бий болгох, тэдэнд англи хэлний мэдлэг, ур чадвараа олон улсын жишигт нийцүүлэн тогтоож, мэдлэгээ бататгахад туслах төдийгүй Англи хэлний багш нарын харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад оршдог билээ.

1. ОЛИМПИАДЫН ҮЕ ШАТ БОЛОН ХУГАЦАА

Олимпиад нь эхний шат, үндэсний шигшээ, бүсийн шигшээ, нэмэлт үе шат, дэлхийн финал гэсэн үндсэн 5 үе шаттайгаар явагддаг.

Шалгалтын үе шат	Шалгалт болох хугацаа	Шалгалтын хэлбэр	Шалгалт болох улс
Эхний шат/ Preliminary Round	2025 оны 03-р сарын 14-16-ны өдөр	Онлайнаар	Монгол улс
Үндэсний шигшээ/National finals	2025 оны 04-р сарын 11-12-ны өдөр	Танхимаар	Монгол улс
Бүсийн шигшээ/Regional Qualifiers	2025 оны 05-р сарын 26-28	Танхимаар	Узбекистан улс, Самарканд хот
Нэмэлт шалгаруулалт/Play-Off Qualifiers	2025 оны 08-р сарын 5-12	Танхимаар	Их Британи улс
Дэлхийн финал/World final	2025 оны 10 сард	Танхимаар	Итали улс

2. ОЛИМПИАДЫН АНГИЛАЛ БА ТҮВШИН

❖ **Эхний шат** буюу **Preliminary round**

Олимпиадад бүртгүүлсэн нийт сурагч, урьдчилан гаргасан хуваарийн дагуу, өөр өөрийн байгаа байршлаас, компьютер эсвэл гар утас ашиглан оролцоно. Онлайн шалгалт хэрхэн өгөх дэлгэрэнгүй зааварчилгааг 2025 оны 02-р сард оруулна.

➤ Олимпиадын эхний шат **хоёр хэсэг тестээс** бүрдэнэ. Үүнд:

1. Уншиж ойлгох чадварын тест

2. Англи хэлний хэрэглээ

Доорх хүснэгтэд тухайн хэсэг бүрт оногдох асуулт, цагийг харуулсан болно. Ижил түвшний бүх оролцогчдын тестийн материал ижил байна.

Өнгөрсөн онуудын тестийн материалуудыг вэбсайтаас авч ашиглах боломжтой. Асуулт бүрд тохирох зөвхөн нэг зөв хариулт байна. Онооны эрэмбэлэлт унших болон сонсох тестийн дундаж дээр суурилна.

	BABY HIPPO	LITTLE HIPPO	HIPPO 1	HIPPO 2 & HIPPO S1	HIPPO 3 & HIPPO S2	HIPPO 4 & HIPPO S3	HIPPO 5 & HIPPO S4	HIPPO S5
УНШИХ	30 асуулт (тус бүр 1 оноо)	30 асуулт (тус бүр 1 оноо)	30 асуулт (тус бүр 1 оноо)	34 асуулт (тус бүр 1 оноо)	34 асуулт (тус бүр 1 оноо)	34 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)
АНГЛИ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)	20 асуулт (тус бүр 1.5 оноо)
НИЙТ АВАХ ОНОО		60 оноо	60 оноо	64 оноо	64 оноо	64 оноо	70 оноо	70 оноо

Доорх хүснэгтэд тухайн хэсэг бүрт оногдох цагийг харуулсан болно.

	BABY HIPPO	LITTLE HIPPO	HIPPO 1 & HIPPO S1	HIPPO 2 & HIPPO S2	HIPPO 3 & HIPPO S3	HIPPO 4 & HIPPO S4	HIPPO 5 & HIPPO S5
УНШИХ	20 минут	20 минут	30 минут	30 минут	30 минут	40 минут	45 минут
АНГЛИ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ	20 минут	20 минут	20 минут	20 минут	20 минут	30 минут	30 минут

❖ **Үндэсний шигшээ шалгаруулалт буюу National finals**

Эхний шатанд тэнцсэн сурагчид урьдчилан төлөвлөсөн байршилд ирж, танхимд, цаасаар шалгалт өгнө. Шалгалтыг хянагч багш хянаж, зохион байгуулна. Үндэсний шигшээ шалгаруулалтын үр дүнгээс хамаарч Дэлхийн финалд шууд өрсөлдөх, бүсийн шигшээд оролцох аль эсвэл нэмэлт үе шатад оролцох эсэх шийдвэр гарна. Үндэсний шигшээ шалгаруулалт хэрхэн явагдах тухай дэлгэрэнгүй мэдээллийг 3-р сард оруулна.

➤ Үндэсний шигшээ шатны тест нь **дараах хэсгээс** бүрдэнэ.

1. **Уншиж ойлгох тест**
2. **Бичгийн тест (30 асуулттай)**
3. **Эссе** (үүнийг зөвхөн оноо тэнцсэн тохиолдолд ашиглана. Энэ нь Baby Hippo болон Little Hippo ангилалд хамаарахгүй)

Асуулт бүрд тохирох зөвхөн нэг зөв хариулт байна. Онооны эрэмбэлэлт унших болон бичгийн тестийн дундаж дээр суурилна.

	BABY HIPPO	LITTLE HIPPO	HIPPO 1	HIPPO 2 & HIPPO S1	HIPPO 3 & HIPPO S2	HIPPO 4 & HIPPO S3	HIPPO 5 & HIPPO S4	HIPPO S5
УНШИХ	30 асуулт (тус бүр 1 оноо)	30 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)	34 асуулт (тус бүр 1 оноо)	34 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)	40 асуулт (тус бүр 1 оноо)
БИЧИХ	30 асуулт (тус бүр 1.5 оноо)	30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)	Эссе+ 30 асуулт (тус бүр 1.5 оноо)
НИЙТ АВАХ ОНОО	75 оноо	75 оноо	85 оноо	79 оноо	79 оноо	85 оноо	85 оноо	85 оноо

Доорх хүснэгтэд тухайн хэсэг бүрт оногдох цагийг харуулсан болно.

	BABY HIPPO	LITTLE HIPPO	HIPPO 1	HIPPO 2 & HIPPO S1	HIPPO 3 & HIPPO S2	HIPPO 4 & HIPPO S3	HIPPO 5 & HIPPO S4	HIPPO S5
УНШИХ	30 минут	30 минут	30 минут	30 минут	40 минут	45 минут	45 минут	50 минут
БИЧИХ	45 минут	45 минут	45 минут	45 минут	45 минут	45 минут	45 минут	45 минут
НИЙТ ЦАГ	1цаг 15мин	1цаг 15мин	1цаг 15мин	1цаг 15мин	1цаг 25мин	1цаг 30 мин	1цаг 30 мин	1цаг 35 мин

❖ Бүсийн шигшээ шалгаруулалт буюу **Regional Qualifiers**

Бүсийн шигшээ шалгаруулалт нь дэлхийн финалд шууд шалгарч чадаагүй үндэсний сурагчид дундаас хамгийн сайн оролцсон сурагчдыг өрсөлдүүлж, дэлхийн финалд оролцох эрх олгох үе шат юм. Тус шалгаруулалтад оролцохдоо **Узбекистан улсын Самарканд** хотод өөрийн биеэр, харгалзагч багшийн хамт ирж оролцоно. Харгалзагч багшийг Хиппо Олимпиадын Монгол дахь зохион байгуулагчийн газраас томилно. Шалгалт танхимаар, цаасан суурьтай явагдана. Сурагч бүсийн сонгон шалгаруулалтад тэнцэж, урилга ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор оролцох үгүйгээ баталгаажуулаагүй тохиолдолд жагсаалтын дараагийн сурагчид урилга очно. Сонгон шалгаруулалтад уригдсан сурагчийн амжилтын доод хувь нь эхний байранд орсон сурагчийн онооны 70%-с багагүй байна. Тус шалгаруулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 5-р сард оруулна.

- Бүсийн шигшээ шатанд оролцогчид **30 асуулт, кроссвордоос** бүрдэх англи хэлний тест өгнө. Жишээ тестүүдийг www.hippo.mn болон www.hippo-olympiad.org сайтаас авч бэлтгэл хийх боломжтой.

❖ Нэмэлт үе шат буюу **Play-Off Qualifiers**

Энэ үе шат нь 2024 оноос эхлэн зохион байгуулагдаж байгаа бөгөөд бүсийн шигшээ болон дэлхийн финалд шууд тэнцээгүй сурагчдаас хамгийн сайн үнэлгээ авсан сурагчдыг сонгож оролцуулах нэмэлт үе юм. Тус үе шат нь 2025 оны 8 сарын 05-12-ны хооронд Их Британи улсад зохион байгуулагдана. Шалгалт тухайн бүс нутагт танхимаар, цаасан суурьтайгаар явагдана. Сурагч Play-Off шалгаруулалтад тэнцэж урилга авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор оролцох үгүйгээ баталгаажуулаагүй тохиолдолд жагсаалтын дараагийн сурагчид урилга очно. Сонгон шалгаруулалтад уригдсан сурагчийн амжилтын доод хувь нь эхний байранд орсон сурагчийн онооны 70%-с багагүй байна.

- Сургалтын төгсгөлд оролцогчид **30 асуулт, кроссвордоос** бүрдэх англи хэлний тест өгнө. Жишээ тестүүдийг www.hippo.mn болон www.hippo-olympiad.org сайтаас авч бэлтгэл хийх боломжтой.

❖ Сүүлийн шат буюу **World Final round**

Дэлхийн өнцөг булан бүрээс амжилттай оролцож, шалгарсан аваргууд Дэлхийн финалын шатанд өрсөлдөнө. Дэлхийн финал нь **2025** оны **10-р сард** Итали улсын Ассисси хотод зохион байгуулагдах ба оролцогч өөрийн биеэр очиж оролцоно. Хугацаа болон шалгаруулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг дүн гарсны дараа шалгарсан оролцогчдод өгөх болно.


- Олимпиадын финалын шатанд оролцогчид Их Британи Улсын Гэйтхаус Авардс байгууллагын **4 чадварыг үнэлэх тест**, мөн **30 асуулт бүхий Англи хэлний хэрэглээний тест** өгнө. Жишээ тестүүдийг www.hippo.mn болон www.hippo-olympiad.org сайтаас авч бэлтгэл хийх боломжтой.

Финалын шатны тестийн түвшин нь эхний шатныхаас нэг түвшин дээгүүр буюу хагас шигшээ шатны түвшинтэй ижил байна.


3. ОЛИМПИАДЫН БҮРТГЭЛ, ТӨЛБӨР

Олимпиадад бүртгүүлэхдээ өөрийн суралцдаг сургуулиар дамжуулан эсвэл хувиараа бүртгүүлэх боломжтой.

Сургуулиас бүртгүүлэх гэж байгаа үед:



Хувиараа бүртгүүлэх үед:



Бүртгэлийн хураамж: 40,000 төгрөг

Олимпиадын тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.hippo.mn -ээс аваарай.